



ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 02

Улаанбаатар

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2023 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, Тахько (ХК) компанийн дүрмийн 7.1.3, 7.2.2 дугаар зүйлийн “б” хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоол, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 10:00 цагаас тус компанийн байр (Чингэлтэй дүүрэг, 5 хороо, МА-III барилга буюу Анкор төвийн хурлын заал)-нд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцүүлэхээр тогтоосугай. Үүнд:
 - Компанийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - Компанийн 2022 оны жилийн тайлан тэнцэлд ээлжит аудит хийсэн компанийн аудиторын дүгнэлтийг танилцуулах;
 - Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох;
 - Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоож, дотоод ажлын зардлын төсвийг батлах.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд бэлтгэх, зохион байгуулах комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын даргад:	Л.Буянбат	ТУЗ-ийн дарга
Гишүүдэд:	Л.Энхнасан	Гүйцэтгэх захирал
	Ш.Мөнх-Очир	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
4. Хуралд бэлтгэх, зохион байгуулах комисст даалгах нь:
 - Ээлжит хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд хүргэх зар мэдээг 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн дотор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр болон компани, арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх;
 - Энэхүү мэдээллийг 15 хоногийн дараа анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэх;
 - Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай мэдэгдлийг холбогдох баримт бичгийн хамт Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагад 2023 оны 03 дугаар сарын 20-ны дотор хүргүүлэх;
 - Хурлаар хэлэлцэх асуудал, хурлаас гарах тогтоол шийдвэрийн төсөл, хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авах ажиллагааг үнэт цаасны арилжаа эрхлэх “Таван Богд ҮЦК” (ХХ) брокер, дилерийн компанитай гэрээ байгуулж, уг гэрээний дагуу зуучлуулан зохион байгуулах;



- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, холбогдох баримт бичгийг санал авах хуудсын хамт үнэт цаасны брокер, дилерийн компанид хэвлэмэл болон цахим хэлбэрээр 2023 оны 03 дугаар сарын 27-ны дотор багтаан хүргүүлэх;
 - Хурлаар хэлэлцэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төсөл болон хувьцаа эзэмшигчдэд танилцуулах баримт бичгийг 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийг дуустал 09-13, 14-17 цагт компанийн байрны 308 тоот өрөөнд танилцуулж, саналын хуудсаар санал авах.
- 5 Хурал зарласан үед хувьцаа эзэмшигчдэд дор дурдсан баримт бичгийг танилцуулахыг хуралд бэлтгэх, зохион байгуулах комисст зөвшөөрсүгэй. Үүнд:
- Компанийн жилийн санхүүгийн тайлан тэнцэл;
 - Санхүүгийн жилийн тайлангийн талаарх аудиторын дүгнэлт;
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн тухай танилцуулга;
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшуулал, зардал;
 - Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдох бусад мэдээлэл.
- 6 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын “Санал авах хуудас”-ны загварыг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
- 7 Ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөр тогтоосугай.
- 8 Хуралд биеэр оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдийн санал авах хуудсыг хүлээж авах сүүлчийн хугацааг 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 17:00 цагаар тогтоосугай.
- 9 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Л.Буянбатыг сонгосугай.
- 10 Хурлын тооллогын комиссын даргаар Б.Сольрагчаа, гишүүнээр Э.Чулуунтогтох, П.Сансартуяа нарыг томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ДАРГА



Л.БУЯНБАТ



**ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН
2023 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС**

Хурал хуралдах огноо: Хурал эхлэх цаг: Дансны дугаар:

Хурал хуралдах газар, хэлбэр:

Хувьцаа эзэмшигчийн (эцэг, эхийн) (нэр)

Регистрийн дугаар Хувьцааны төрөл (энгийн, давуу)

Хувьцааны тоо

А. Ердийн аргаар санал авах асуудал

№	Хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн товч утга	Зөвшөөрсөн (+)	Татгалзсан (+)	Түдгэлзсэн (+)
1				
2				
3				
4				
5				
6				

Б. Кумулятив аргаар санал авах асуудал

№	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
Ердийн гишүүн		
1		
2		
3		
4		
5		
6		
7		
8		
9		
10		
Хараат бус гишүүн		
1		
2		
3		
4		

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг, нэр ()

Санал авах хуудсыг үйлдсэн оны дүгээр сарын -ны өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцож тоолсон
Тооллогын комиссын дарга ()

Хүчингүйд тооцсон бол түүний шалтгаан

.....

.....

.....

.....

.....